


УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/226/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Р.Аюуш
Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1. Хараат бус аудиторын дүгнэлт | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 5 |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 9 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 10 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 10 |
| 4. Аудитын тайлан | 13 |
| 4.1 Ерөнхий зүйл | 13 |
| 4.2 Материаллаг байдал..... | 14 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..... | 14 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 14 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 5. Аудитын илрүүлэлт | 15 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шүүд захирагч |
| НА | Нийцлийн аудит |



УЛААНГОМ СУМЫН 13 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.БАЯСАА ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400. Увс аймаг. Улаангом сум.
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17.
E-mail: uvs@auudit.gov.mn

2023.02.18 № УВА-2023/226/НА-СТА-ТМС
танай _____ -ны № _____ -г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 176 дугаар дүгнэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/496 дугаар захирамжаар Улаангом сумын 10 дугаар багийн нутаг дэвсгэрт сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ эрхлэх Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг байгуулагдсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

0200000048

Бусад асуудлын хэсэг

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж, газар балансад бүртгэлгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөг/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|----------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 0.00 | 17,300,427.00 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 648,507.00 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 0.00 | 648,507.00 |
| 31210 | Төгрөг | 0.00 | 648,507.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 648,507.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 0.00 | 16,651,920.00 |
| 35400 | Хангамжийн материал | 0.00 | 16,651,920.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 0.00 | 223,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 0.00 | 2,051,340.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 14,377,280.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 0.00 | 31,550,357.51 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 0.00 | 31,550,357.51 |
| 39200 | Биет хөрөнгө | 0.00 | 30,583,690.85 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 0.00 | 20,758,352.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -866,252.03 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 0.00 | 10,946,295.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -254,704.92 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 0.00 | 966,666.66 |
| 39301 | Программ хангамж | 0.00 | 1,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -33,333.34 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 0.00 | 48,850,784.51 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 0.00 | 48,850,784.51 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 0.00 | 48,850,784.51 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 0.00 | 48,850,784.51 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 48,850,784.51 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 0.00 | 48,850,784.51 |



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------|---|-------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 0.00 | 150,671,927.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 0.00 | 41,971,027.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 0.00 | 41,971,027.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0.00 | 3,617,130.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0.00 | 3,617,130.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 28,087,517.80 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 0.00 | 10,266,380.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 0.00 | 108,700,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 0.00 | 108,700,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 108,700,900.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 0.00 | 101,821,143.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 101,821,143.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 101,821,143.29 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.00 | 74,956,063.00 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 59,093,502.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 12,233,112.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 320,000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 3,309,449.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.00 | 9,369,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 6,371,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 749,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 599,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 149,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 1,499,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 9,825,190.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 9,825,190.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 7,220,090.29 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 5,165,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 900,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 0.00 | 1,154,290.29 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 0.00 | 48,850,784.51 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 0.00 | 48,850,784.51 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


20

ЗӨРЧИЛГҮЙ
САНАА ДАТГАХ

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|--------|--|-------------|----------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 0.00 | 108,700,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 0.00 | 108,700,900.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 0.00 | 108,700,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 108,700,900.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 107,052,393.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 107,052,393.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 107,052,393.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 0.00 | 74,956,063.00 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 59,093,502.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 12,233,112.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 320,000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 3,309,449.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.00 | 9,369,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 6,371,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 749,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 599,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 149,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 1,499,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 11,876,530.00 |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 11,876,530.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 0.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 10,400,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.00 | 9,200,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 1,200,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 0.00 | 1,648,507.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 0.00 | 1,000,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 1,000,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 1,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 1,000,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | 0.00 | -1,000,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.00 | 648,507.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 648,507.00 |



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| | | | | | <i>/төгрөг/</i> |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 1 | 2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 11 | 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 48,850,784.51 | 48,850,784.51 |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 48,850,784.51 | 48,850,784.51 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| | | | | | <i>/төгрөг/</i> |
|--------|--|----------------|-----------------------------|-----------------|-----------------|
| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 108,700,900.00 | 108,052,393.00 | 648,507.00 | |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 108,700,900.00 | 108,052,393.00 | 648,507.00 | |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 108,700,900.00 | 108,052,393.00 | 648,507.00 | |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 74,958,800.00 | 74,956,063.00 | 2,737.00 | |
| 210101 | Үндсэн цалин | 60,739,400.00 | 59,093,502.00 | 1,645,898.00 | |
| 210102 | Нэмэгдэл | 12,000,000.00 | 12,233,112.00 | -233,112.00 | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 320,000.00 | 320,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 2,219,400.00 | 3,309,449.00 | -1,090,049.00 | |

САГАА ДҮГИЭЛТ


| | | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|-------------------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,369,800.00 | 9,369,800.00 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,371,400.00 | 6,371,400.00 | 0.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 749,600.00 | 749,600.00 | 0.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 599,700.00 | 599,700.00 | 0.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 149,900.00 | 149,900.00 | 0.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,499,200.00 | 1,499,200.00 | 0.00 |
| 2105 | Нормативт зардал | 11,880,000.00 | 11,876,530.00 | 3,470.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,880,000.00 | 11,876,530.00 | 3,470.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 450,000.00 | 450,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,042,300.00 | 11,400,000.00 | 642,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,842,300.00 | 10,200,000.00 | 642,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,200,000.00 | 1,200,000.00 | 0.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 108,700,900.00 | 108,700,900.00 | 0.00 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 108,700,900.00 | 108,700,900.00 | 0.00 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 108,700,900.00 | 108,700,900.00 | 0.00 |
| 37 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 648,507.00 | -648,507.00 |
| 631 | СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА | 1.00 | 1.00 | 0.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 26.00 | 26.00 | 0.00 |
| | удирдах | 1.00 | 1.00 | |
| 650004 | СfБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 14.00 | 14.00 | 0.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 | 0.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10.00 | 10.00 | 0.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь хүүхдийн сурах үйлийг дэмжих сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин



Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн хувьд:

- ✓ Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгал болон татварын тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.


3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд



Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 48,850.8 мянган төгрөг байна. Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь 2022 оны 9 дүгээр сараас эхлэн байгуулагдсан.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|----------------|-----------------|-----------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 648.5 | 648.5 |
| Бараа материал | 0.00 | 16,651.9 | 16,651.9 |
| Үндсэн хөрөнгө | 0.00 | 31,550.4 | 31,550.4 |
| Нийт хөрөнгө | 0.00 | 48,850.8 | 48,850.8 |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 0.00 | 48,850.8 | 48,850.8 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 0.00 | 48,850.8 | 48,850.8 |

Тайлант онд мөнгөн хөрөнгө 648.5 мянга, бараа материалын дансны үлдэгдэл 16,651.9 мянга, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31,550.4 мянга төгрөг байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 48,850.8 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь 2022 онд шинээр үүссэн байгууллага учир 2022 оны төсвийн төсөлд дээд шатны төсвийн захирагчид хүргүүлээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 108,700.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 108,700.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 108,052.4 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 648.5 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|------------|-----------|-------|---------|
| 1 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол, 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 77,856.8 | 77,856.8 | 0.00 | 100% |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
 20
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАА ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|----------|----------|-------|-------|
| 2 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол, 81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах | 17,121.8 | 17,119.1 | 2.7 | 99.9% |
| 3 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол, 81605-эрүүл мэндийг дэмжих | 800.0 | 800.0 | 0.00 | 100% |
| 4 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол, 81807-цэцэрлэгийн хүүхдийн хоол | 11,880.0 | 11,876.5 | 3.5 | 99.9% |
| 5 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол, 81816- хүүхдэд ээлтэй орчин | 642.3 | 0.00 | 642.3 | 0.00 |
| 6 | 71801-Сургуулийн өмнөх боловсрол, 81823- боловсролын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих | 400.0 | 400.0 | 0.00 | 100% |

Бараа үйлчилгээний бусад зардал 642.3 мянган төгрөг, хоол хүнсний зардал 3.5 мянган төгрөгийн хэмнэлт гарган мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 648.5 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН


4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.



4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 108,700.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 1,087.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 869.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг хэвээр үлдээхээр болов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтад “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг зөрчин цэцэрлэгийн арга зүйч багшид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил болох сургалт хийсэн гэж 100.0 мянган төгрөгийн хөлс олгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.


Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн хувьд 2022 оны 9 дүгээр сард шинээр байгуулагдсан тул шилэн дансны хэрэгжилтийг шалгах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэл оруулах талбар байгаагүй 2023 оны 1 дүгээр сард шинээр нээлгэсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасан байна.

Тайлант онд Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийг 28.5 дахь хэсгийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.



4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 420.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 320.0 мянган төгрөгийн 1 зөрчилд дахин давтан гаргахгүй байх зөвлөмж, 100.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 39.1.3-д “Хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтад “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалтад “Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах”, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт “Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх” гэж заасныг зөрчин цэцэрлэгийн арга зүйч багшид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дотоод сургалт хийсний хөлс 100.0 мянган төгрөгийг олгосныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө өөртөө 80.0 мянган төгрөгийн унааны хөнгөлөлт авсан. Мөн албан хаагчдад унааны хөнгөлөлт олгохдоо 3 албан хаагчдад /заах арга зүйч, нягтлан бодогч, нярав/ тус бүр 80.0 мянга нийт 320.0 мянган төгрөг илүү олгож тэгш бус байдал үүсгэсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй

УВС АИМАГ НАХАГБЭРИЙН АУДИТЫН ГАЗАР

СЭВЭГЭЙН
ОЛОН ДАТГАЛ

нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсэгт “Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах” гэж заасныг тус тус мөрдөж ажиллах ажиллах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-------|---------------|-------|-----------------|------|---------|-------|--------------------------------------|---------------------|---|------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй | 2 | 420.0 | 1 | 100.0 | 0.00 | 0.00 | 1 | 320.0 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 2 | 420.0 | 1 | 100.0 | 0.00 | 0.00 | 1 | 320.0 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2022 оны 02 сарын 18-ны өдөр





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 01/05/00040457
УВА-2023/026/НА-СГА-ТЦС

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь арга зүйч багшид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан дотоод сургалт хийсний хөлс 100.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалтад "Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", 39.1.3-д "Хуульд нийцээгүй шийдвэр гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалтад "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэгт "Салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал зөвлөгөөн болов газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3 дахь заалтад "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаангом сумын 13 дугаар цэцэрлэг нь арга зүйч багшид албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан дотоод сургалтын хөлс 100,000 /Нэг зуун мянга/ төгрөгийг Цэцэрлэгийн эрхлэгч Б.Баясаагаар төлүүлж Төрийн сан банкин дахь орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.


2. Актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэхийг Улаангом сумын 13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Б.Баясаа, нягтлан бодогч Я.Оюунцэцэг нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Я.ОЮУШ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ